

## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ БОДЛОГО

Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон түүнтэй холбогдох бусад хууль, тогтоомжийг дагаж мөрдөх бодлогыг манай байгууллага хатуу баримтална.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотойгоор байгууллага дотооддоо дараах арга, хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Харилцагчаа танин мэдэх;
- Сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааг мэдээлэх;
- Баримтыг архивлах;
- Дотоод хяналтыг хэрэгжүүлэх;
- Эрсдэлийн үнэлгээ ба удирдлагыг бататгах;
- Комплаенсийн удирдлагыг хийх.

Иймд, харилцагчтай холбоо тогтоох, үйлчилгээ үзүүлэхээс өмнө бид Монгол Улсын Мөнгө Угаах болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх хуулийн дагуу дараах бичиг баримтыг нягтлан шалгах үүрэгтэй байдаг. Энэ нь харилцагч танд тохирсон үйлчилгээ үзүүлэх, таныг аливаа хууль бус үйл ажиллагаа зэргээс хамгаалах олон талын ач холбогдолтой юм.

### ИРГЭН БОЛ:

- Хүчин төгөлдөр иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорт;
- Оршин суугаа болон холбоо барих хаяг, утас, мэйл хаяг;
- Ажил эрхлэлт бизнесийн мэдээлэл, хөрөнгө орлогын эх үүсвэр;
- Гадаад улсын иргэн бол хүчин төгөлдөр Монгол улсад оршин суух үнэмлэх;
- Холбогдох банкнаас шаардсан бусад мэдээлэл.

### ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:

- Байгууллагын дүрэм;
- Хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх удирдлагын талаарх товч мэдээлэл;
- Дансны хөрөнгийг захиран зарцуулж буй этгээд нь гадаад улсын иргэн бол Монгол улсад оршин суух үнэмлэх;
- Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл болон харилцагчийн өмчлөл болон хяналт зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой мэдээлэл;
- Бизнесийн болон банканд данс нээхдээ баримтжуулан хүлээн зөвшөөрсөн баримтын хуулбар;
- Хуулийн этгээдийн төрлөөс шалтгаалсан нэмэлт мэдээлэл;
- Холбогдох банкнаас шаардсан бусад мэдээлэл.

“Эцсийн өмчлөгч” гэж харилцагчийн үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хувь хүнийг, эсхүл хуулийн этгээдийг хуулийн этгээд өмчилж байвал өмчлөгч хуулийн этгээдийн үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж байгаа **хувь хүнийг** ойлгоно.

## МӨНГӨ УГААХ ГЭДЭГТ ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ОЙЛГОНО

- Хууль бус замаар мөнгө / хөрөнгийг санаатайгаар гэмт хэрэг үйлдэж олох
- Гэмт хэрэгт холбогдолтой мөнгө / хөрөнгийг мэдсээр байж байршуулах, нуун далдлах, шилжүүлэх, хувиргахад дэмжлэг үзүүлэх
- Гэмт хэрэгт холбогдолтой мөнгө / хөрөнгийг мэдсээр байж ашиглах, хэрэглэх, захиран зарцуулах

Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь зөвхөн банк санхүүгийн байгууллагад хамаатай бус улс орны санхүүгийн систем, олон улс дахь нэр хүнд, гадаад дотоод худалдаа, гадаад шилжүүлэг, хөрөнгө оруулалт татах зэрэг олон талын ач холбогдолтой байдаг тул бид түүнийг ухамсарлан мөнгөн угаах, терроризмтой тэмцэхийн эсрэг хатуу бодлого баримталж байгууллага дотооддоо баримталж дүрэм, журмыг нэвтрүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих болно.